



ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛ, СОНГУУЛИЙН ОРОЛЦОО



Улаанбаатар 2024

ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛ, СОНГУУЛИЙН ОРОЛЦОО

(Сургалтын гарын авлага)

Улаанбаатар

2024

Энэхүү гарын авлагыг Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх Газрын захиалгаар бүтээв. Тус бүтээлд илэрхийлсэн агуулга нь зохиогчдын үзэл санаа бөгөөд Авлигатай тэмцэх газрын албан ёсны байр суурь биш болно.

Боловсруулсан:

Ц.Бүжидмаа (доктор Ph.D)

Хянан тохиолдуулсан:

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
УИХ	Улсын их хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ЭЗОС	Эмэгтэйчүүд, Залуучуудын Оюуны Сан
ТББ	Төрийн бус байгууллага

МОДУЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын модулийн зорилго, зорилтууд:

Зорилго. Энэхүү сургалтын хөтөлбөр нь иргэний улс төрийн боловсролын талаар дөрвөн үндсэн сэдвээр цогц мэдлэг олгоход чиглэсэн. Сургалтыг оролцогчдыг идэвхтэй оролцоонд татан оролцуулах интерактив сургалтын арга зүйг ашиглан зохион байгуулна.

Зорилтууд:

1. Иргэний улс төрийн боловсролын суурь ойлголт болох ардчиллын зарчим, үнэт зүйлс болон иргэдийн эрх, үүргийн талаар гүнзгий ойлголт өгөх.
2. Оролцоо, түүний шатлал, түвшин, ач холбогдлын тухай мэдлэг олгох
3. Иргэний улс төрийн боловсрол, түүний ач холбогдол, иргэний улс төрийн оролцооны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, иргэдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд сэдэл өгөх
4. Сонгууль, сонгуулийн тогтолцооны тухай болон, сонгуулийн тогтолцооны төрөл, ялгаа, давуу болон сул талууд, сонгуулийн оролцооны хэлбэрүүдийн талаар ойлголт мэдлэг олгох

Хүрэх дүн:

- Оролцогчдын ардчиллын зарчим, үнэт зүйлийн талаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, идэвхи оролцоог нэмэгдүүлснээр тэд бүтээлчээр оролцох хүсэл тэмүүлэлтэй болсон байна.
- Оролцогчид сонгуулийн тогтолцооны хэлбэрүүд тэдгээрийн ялгаа, давуу болон сул талыг мэддэг болсон байна.
- Иргэний улс төрийн оролцооны талаарх үүрэг хариуцлагаа ухамсарлах, улс төрийн үйл явцад хариуцлагатай оролцох сэдэл тэмүүлэл бий болсон байна.
- Сонгуулийн оролцооны хэлбэрүүдийн талаар мэдлэгээ нэмэгдүүлснээр оролцогчдын сонгогчийн боловсролыг дэмжинэ.

Хүснэгт 1. 1. Модулийн агуулга

Хичээлүүд	Хамрах сэдэв
Хичээл 1. Ардчиллын үнэт зүйлс, эрх чөлөө ба иргэний үүрэг хариуцлага	<ul style="list-style-type: none">• Ардчиллын тухай ойлголт, хэмжүүр• Ардчиллын үнэт зүйл, зарчмууд• Эрх чөлөө ба үүрэг хариуцлага; иргэний нийгмийн үүрэг.
Хичээл 2. Иргэний оролцоо, оролцооны хэлбэрүүд	<ul style="list-style-type: none">• Ардчилсан нийгмийн хөгжилд иргэний оролцоо• Иргэний оролцооны хэлбэрүүд
Хичээл 3. Иргэний улс төрийн боловсрол ба нийгмийн хариуцлага	<ul style="list-style-type: none">• Иргэний улс төрийн боловсрол гэж юу вэ?• Иргэний улс төрийн боловсролын ач холбогдол• Иргэний улс төрийн оролцоо, улс төрийн идэвхтэй байдал, иргэдийн үүрэг, хариуцлага
Хичээл 4. Сонгуулийн тогтолцоо, хариуцлагатай сонгогч	<ul style="list-style-type: none">• Сонгуулийн ач холбогдол,• Сонгууль, Сонгуулийн системийн төрлүүд• Монгол Улсын сонгуулийн системийн онцлог• Сонгуулийн оролцооны хэлбэрүүд• Сонгогчийн эрх, үүрэг ба хариуцлага:

Сургалтын арга зүй:

- Сургалтын явцад тухайн модулийн агуулгын хүрээнд багшийн мэдээлэл, онолын мэдлэг олгох сургалтыг практиктай хослуулах, суралцагчдын бүтээлч оролцоо, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдлэг бүтээх арга зүйг сонгон ашиглана.
- Сургалтын материал, техник хэрэгсэл ашиглан (гарын авлага, лекцийн материал, видео бичлэг, кейс гэх мэт) сургалтыг аль болох шинэлэг арга зүйгээр зохион байгуулж, суралцагчдад хүргэнэ.
- Лекцийн арга, хэлэлцүүлэг, багаар ажиллах, асуудлын болон шийдлийн мод, эрэмбийн матрицын арга, картын арга, тохиолол шинжлэх арга зэрэг идэвхтэй сургалтын арга, хэлбэрүүдээс ашиглана.
- Дасгал ажил болон үнэлгээнд ашиглах жишиг асуулт, ажлын хуудсуудыг ашиглана.

Үнэлгээ:

Сургалтын үнэлгээгээр сургалтын дараах хандлага, мэдлэг өөрчлөгдсөн эсэхийг тодорхойлно. Үнэлгээг сургалтын эхлэл, төгсгөлд асуулгын болон нээлттэй самбарын үнэлгээний аргаар авна.

1. Сэтгэл ханамж
 - Сургалтын явцад, эсвэл дараа нь санал асуултын хуудсаар оролцогчдын сэтгэл ханамжийн байдлыг үнэлнэ.
2. Мэдлэг эзэмшсэн байдал
 - Оролцогч сургалтын явцад заасан хичээлийн агуулгыг хэрхэн ойлгосон мөн өмнөх хичээлтэй харьцуулах, уялдуулах, дүгнэлт өгөх зэргийг үнэлнэ.
3. Хандлага, төлөвшил
 - Сургалтаар олж авсан мэдлэг, чадварыг бодитоор хэрэгжүүлэхэд хувь хүний бие даан болон багаар ажиллах чадвар, бусадтай харилцах харилцаа, хандлагын өөрчлөлт зэргийг ажиглалт, ярилцлага, бичгийн хэлбэрээр үнэлнэ.
4. Үр дүн
 - Оролцогч сургалтаар эзэмшсэн мэдлэг ур чадвараа бодит байдалд хэрэглэх чадвар, эрмэлзэл, сэдэл төрсөн тухай бичгийн /ажлын дэвтэрт бичих/ болон харилцан ярилцах, ажиглалт хийх хэлбэрээр үнэлнэ.
 - Сургалтын арга зүй зохион байгуулалтаас төрсөн сэтгэгдэлийг бичгээр болон онлайн тестээр авна.
 - Сургалтын явцад хийсэн дасгалажил, шинжилгээ болон бусад бүтээлч багийн ажлуудын оролцоо, үр дүнгээр үнэлнэ.

ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛ, СОНГУУЛИЙН ОРОЛЦОО СУРГАЛТЫН МОДУЛЬ

Модулийн товч танилцуулга: Энэхүү сургалтын хөтөлбөр нь иргэний улс төрийн боловсролын талаар дөрвөн үндсэн сэдвээр цогц мэдлэг олгоход чиглэсэн. Сургалт нь оролцогчдыг идэвхтэй оролцоонд татан оролцуулах интерактив сургалтын арга зүйг ашиглан зохион байгуулагдана.

Хичээлүүд	Хамрах сэдэв	Дасгал ажил	Дасгалын зорилго
Хичээл 1. Ардчиллын үнэт зүйлс, эрх чөлөө ба иргэний үүрэг хариуцлага <p style="text-align: center;">2 цаг</p>	<ul style="list-style-type: none"> • Ардчиллын тухай ойлголт, хэмжүүр • Ардчиллын үнэт зүйл, зарчмууд • Эрх чөлөө ба үүрэг хариуцлага; иргэний нийгмийн үүрэг. 	"Ардчиллын үнэт зүйлсийн мод"	<ul style="list-style-type: none"> • Ардчиллын үнэт зүйлсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх • Нийгэмд илэрч буй эдгээр үнэт зүйлсийн ач холбогдлыг тунгаан ярилцах. • Хамтын хүчээр ардчиллын үнэт зүйлсийг хэрхэн тэтгэх арга замыг тодорхойлох.
Хичээл 2 . Иргэний оролцоо, оролцооны хэлбэрүүд <p style="text-align: center;">2 цаг</p>	<ul style="list-style-type: none"> • Ардчилсан нийгмийн хөгжилд иргэний оролцоо • Иргэний оролцооны хэлбэрүүд 	<ul style="list-style-type: none"> • Оролцоотой холбоотой хэлц үг зохиох утгыг хэлэлцэх • Мэдлэг сорих тест 	<ul style="list-style-type: none"> • Оролцооны тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, оролцоог идэвжүүлэх
Хичээл 3. Сонгууль, сонгуулийн тогтолцооны төрлүүд <p style="text-align: center;">2 цаг</p>	<ul style="list-style-type: none"> • Сонгуулийн ач холбогдол, • Сонгууль, Сонгуулийн системийн төрлүүд • Монгол Улсын сонгуулийн системийн онцлог 	Нөхцөл байдлын шинжилгээ	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын үе үеийн УИХ болон орон нутгийн сонгуулийн тогтолцоо, тэдгээрийн давуу ба сул тал, сонгуулийн үр дүнд гарсан өөрчлөлтүүдийг судлах
Хичээл 4. Сонгуулийн оролцоо, хариуцлагатай сонгогч <p style="text-align: center;">2 цаг</p>	<ul style="list-style-type: none"> • Сонгуулийн оролцооны хэлбэрүүд (санал өгөх, сонгуульд нэр дэвших, хяналт тавих, олон нийтийн кампанит ажил). • Сонгогчийн эрх, үүрэг ба хариуцлага: 	"Миний сонголт, миний хариуцлага" дасгал ажил	<ul style="list-style-type: none"> • Хариуцлагатай сонгогч байх нь зөвхөн саналаа өгөх биш, харин нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, шийдвэр гаргах чадвар, хариуцлагатай байдлыг судлах хэрэгтэйг ойлгуулах • Сонголт нь ирээдүйд хэрхэн нөлөөлөхийг ойлгох нь хариуцлагатай сонгогч байх чухал хэсэг болохыг ойлгуулна

Хичээл 1. Ардчиллын тухай ойлголт, ардчиллын зарчим, үнэт зүйлс

Зорилго	Иргэний улс төрийн боловсролын суурь ойлголт болох ардчиллын зарчим, үнэт зүйлс болон иргэдийн эрх, үүргийн талаар гүнзгий ойлголт өгөх.
Дэд сэдэв	<ul style="list-style-type: none">• Ардчиллын тухай ойлголт, ардчиллын зарчим, үнэт зүйлс• Ардчиллын тогтолцооны бүтэц, эрх зүйн үндэс;• Эрх чөлөө ба үүрэг хариуцлага; иргэний нийгмийн үүрэг.
Зорилгот бүлэг	<ul style="list-style-type: none">• Иргэний нийгмийн сургагч багш нар
Зохион байгуулах алхамууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 20 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 30 мин• Сургалтын үнэлгээ-10 минут
Сургалтын эрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоч

Сургагч багшид өгөх зөвлөгөө

- Бэлтгэсэн лекцийг ашиглан мэдээлэл хүргэхдээ асуулт байгаа эсэхийг лавлаж, харилцан ярилцаж явуулна.
- Дасгал ажлаар оролцогчдын хэлэлцүүлэг, санааг нэгтгэн дүгнэж, ардчилал бол хамтын үнэт зүйлсээс бий болдог гэдгийг ойлгуулах.

Сэдэлжүүлэх дасгал ажил:

Зорилго: Нэр томъёо, ойлголтуудыг бататгах, сэдэлжүүлэх

Аргачлал:

1. Оролцогчдыг багт хувиарлан суулгана.
2. Баг тус бүрд ардчиллын үнэт зүйлсийн талаар товч танилцуулга тарааж өгнө. Эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, олон ургалч үзэл, хууль дээдлэх гэх мэт.
3. Багуудад дараах асуултын дагуу ярилцаж хариултаа нэгтгэн бусад багууддаа танилцуулна.
 - "Ардчилал гэж таны бодлоор юу вэ?"
 - "Ардчиллын энэхүү үнэт зүйлийн талаарх ойлголтыг тайлбарлана уу"

Хамаарах нэр томъёо.

- Эрх чөлөө,
- Тэгш байдал
- Шударгас ёс
- Хүний эрх
- Хууль дээдлэх ёс
- Олон ургальч үзэл

Сэдэвтэй холбоотой мэдээлэл

Багш дараах товч агуулгын хүрээнд бэлтгэсэн танилцуулгыг ашиглан оролцогчдод мэдээлэл өгнө.

Ардчиллын тухай ойлголт, ардчиллын зарчим, үнэт зүйлс



Зураг 1. Ардчиллын тухай ойлголт

Эх сурвалж: ChatGPT-ийн тусалцаатайгаар бүтээв.

Ардчиллын тухай ойлголт: Одоогоос 120 жилийн өмнө дэлхийд 20 орчим ардчилсан улс байсан бол XIX зууны дундаас XX зууны эхэн хүртэл 120 орчим болсноор дэлхийн нийт хүн амын 70% нь ардчилсан нийгэмд амьдрах болсон юм. Эдгээр улс орнууд цөм янз бүрийн түвшинд өөр өөрийн аргаар ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлж ирсэн байна.

Иймд ардчиллын тухай ойлголт ч олон янзаар өргөн хэрэглэгдэж ирсэн юм. Тухайлал, ардчиллыг энгийн сэтгэлгээний түвшинд эрх чөлөө, улс төрийн дэглэм, олонхийн засаглал, нийгмийн зохион байгуулалтын хэлбэр гэх зэргээр тайлбарлаж байна.

Юутай ч өнөөдөр хүний эрх, эрх чөлөөг нийгмийн харилцааны тулгуур болгон үндсэн хуулиндаа тунхаглаж, уг эрх, эрх чөлөөг аль болох өргөн утгаар эдлүүлэхийг эрхэм зорилгоо болгосон нийгмийг ардчилсан нийгэм хэмээн нэрлэж байна.¹ Өөрөөр хэлбэл ардчиллыг эрх чөлөө, тэгш байдал, хүний эрх зэрэг үнэт зүйлсэд тулгуурласан нийгмийн байгуулалтын хэлбэр гэж үзэх болжээ.

Ардчилалд шилжих үйл явц тухайн улс үндэстний нийгмийн онцлог, хүн ардынх нь уламжлал, түүхэн туршлагаар баяжин дэлхийн өнцөг булан бүрд өрнөхийн зэрэгцээ Эртний Грек Ромын үеэс улбаалан ардчиллын тухай онол үзэл баримтлалууд үүсэн хөгжиж өнөөдөр өөр өөрийн онцлог бүхий урсгал чиглэлүүдтэй болжээ.

АРДЧИЛЛЫН ОНОЛ

СОНГОДОГ ОНОЛ

- Нийгмийн гишүүн бүр өөрсдийн амьдралтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой.
- Олон түмэн төр засгаа сонгож бий болгох эрхтэй. Төр засаг нь ард түмнийхээ өмнө бүрэн хариуцлага хүлээх ёстой.
- Хүний эрх, эрх чөлөөг хэнээ ч үл хамаарах жам ёсны зүйл хэмээн хүлээн зөвшөөрч, нэр төр, өмч хөрөнгийг нь хамгаалах, авьяас чадвараа хөгжүүлэхэд хүн бүрийг тэгш боломжоор хангах,

ЭЛИТИЙН ОНОЛ

- Аль нэг талаараа шалгарсан давуу талтай элитүүд нийгмийг удирдаж, олонхи нь тэднийг дагаж амьдарна.
- Тэд нийгмийн үнэт зүйлсийн талаар нэгдсэн үзэл санаатай байж, системээ хамгаалахад зорилго бодлого нь чиглэгдэх ёстой.
- Элитийн бодлогод олон түмний сайн сайхан байдал гол байр эзлэх ёстой.

ОЛОН УРГАЛЧ ОНОЛ

- Янз бүрийн нам бүлэглэлүүд улс төрийн амьдралд зайлшгүй байх ёстой.
- Нийгэм дэх өөр хоорондоо өрсөлдсөн олон хүчнүүдийг төлөөлсөн элитүүд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ.
- Тэд иргэдийн өмнө бус нам бүлэглэлүүдийнхээ өмнө хариуцлага хүлээнэ.

¹ Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь .УБ., 2006., х.16

Зураг 2. Ардчиллын онолууд

Төрийн эрх мэдлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх гол үүрэг ямар субъектэд оногдож байна вэ гэдгээр ардчиллыг дараахь байдлаар ангилдаг.

Либераль
ардчилал

Олон ургальч
ардчилал

Хамтын буюу
тоталитар ардчилал

Төрийн эрх мэдлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх гол үүрэг ямар субъектэд оногдож байна вэ гэдгээр ардчиллыг дараахь байдлаар ангилдаг.

Либераль
ардчилал

Олон ургальч
ардчилал

Хамтын буюу
тоталитар ардчилал

Хувь хүн төрийн эрх мэдлийн уг сурвалж, хувь хүн төрөөс илүү эрх мэдэлтэй байх ёстой.

Улс төрийн бодлогын гол оролцогчид нь нэгэн сонирхлоор нэгдсэн бүлгүүд, улс төрийн намууд байна.

Ард түмэн бүхэлдээ юм уу эсвэл түүнтэй адилтгах том нийтлэг төр, засгийн эрх мэдлийн субъект байна.

Хэн эрх мэдлийг хэрэгжүүлж байна вэ, ард түмэн үү эсвэл тэдний төлөөлөгчид үү гэдгээр нь ардчиллын хэлбэрийг тодорхойлдог.

Шууд ардчилал

Төлөөллийн ардчилал

Иргэд өөрсдөө шууд шийдвэр гаргаж, төрийн үйл хэрэгт оролцдог засаглалын хэлбэр.
Иргэд тодорхой хууль, бодлого, шийдвэр гаргах явцад шууд оролцож, саналаа өгч шийдвэрлэдэг.
Энэ нь төлөөлөгчдийг дамжуулахгүйгээр, иргэдийн саналаар шууд шийдвэрлэгддэг ардчиллын хэлбэр

Иргэд өөрсдийнхөө нэрийн өмнөөс шийдвэр гаргах төлөөлөгчдийг сонгодог засаглалын хэлбэр.
Иргэд сонгуульд оролцож, өөрсдийг нь төлөөлөх төлөөлөгчдөө сонгож, тэдгээр төлөөлөгчид нь хууль тогтоох болон бодлого боловсруулах үүргийг гүйцэтгэдэг

Ардчиллын тухай онол нь “ард түмний засаглал” гэсэн язгуур утгаараа бодитой хэрэгжиж, улс орны хөгжлийн зүй тогтол болох нь төдийлөн үгүй бөгөөд гагцхүү тэдгээрийг хослуулах замаар бодит амьдралд биеллээ олжээ хэмээн судлаачид дүгнэж байна².

Ардчиллын хэрэгжилт тухайн орны хөгжлийн түүхэн нөхцөл байдал, эдийн засаг геополитикийн болон бусад онцлогуудаас хамаарч байгаа бөгөөд ихэнхи оронд Парламентийн хэлбэрээр оршиж байна. Тухайлбал АНУ-ын холбооны систем, хамтын ажиллагаа, тохиролцоо, зөвшилцлийг гол болгодог бол Британы ардчиллын тухай үзэл баримтлал нь олонхийн хүчтэй төрийг эрхэмлэдэг.

Ардчиллын хэрэгжилт тухайн орны хөгжлийн түүхэн нөхцөл байдал, эдийн засаг геополитикийн болон бусад онцлогуудаас хамаарч байгаа бөгөөд ихэнхи оронд Парламентийн хэлбэрээр оршиж байна. Тухайлбал АНУ-ын холбооны систем, хамтын ажиллагаа, тохиролцоо, зөвшилцлийг гол болгодог бол Британы ардчиллын тухай үзэл баримтлал нь олонхийн хүчтэй төрийг эрхэмлэдэг.

Ардчиллын шалгуурын талаар маш олон эх сурвалжууд байгаа бөгөөд эрдэмтэн Р.Далийн тодорхойлсноор ардчиллын хамгийн наад захын шалгуур нь

1. Насанд хүрэгчдийн бүх нийтийн сонгуулийн эрх
2. Давтамжтай, чөлөөт, өрсөлдөөнт, шударга сонгууль
3. Нэгээс дээш тооны улс төрийн намууд
4. Мэдээллийн альтернатив эх сурвалжууд болно³.



Бүх нийтийн сонгууль, олон намын чөлөөт өрсөлдөөн, иргэдийн сонгох, сонгогдох эрх баталгаажсан байдал, засаглагч хүчин сонгуулиар солигдох боломжтой тогтолцоо бүрэлдэх нь ардчиллыг ардчилсан бус дэглэмээс ялгах гол шалгуур юм.

Ардчилал хөгжиж, түүний онол илүү төгс тодорхой болохын хирээр сонгуульд ардчилал нь зөвхөн гарааны нөхцөлд тооцогдох болов. Эрх зүйт төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдал, засаг төрийн хариуцан тайлагнах, нээлттэй байдал зэрэг нь ардчиллын гол баталгаа болжээ.

Сүүлийн жилүүдэд ардчиллын чанарын асуудал чухлаар тавигдаж эхлэв. Чанартай “сайн” ардчилал гэдэг нь иргэдийнхээ эрх чөлөө, улс төрийн тэгш байдлыг хангахын зэрэгцээ, төрөө хянах боломжоор хангасан дэглэмийг хэлнэ. Өөрөөр хэлбэл хууль болон төр засгийн шийдвэрүүдийн үр нөлөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдал, сонгогдсон төлөөлөгчид, албан тушаалтнуудын үйл ажиллагааг иргэд хянаж байх ёстой.

Ардчиллын чанарын тухай ойлголтод хариуцан тайлагнах тогтолцоо (нийгмийн эгэх хариуцлага гэж орчуулсан нь бий) онцгой байр эзэлдэг. **Хариуцан тайлагнах босоо тогтолцоо гэдэг нь** сонгогдсон төлөөлөгчид эсвэл төрийн байгууллагууд сонгогч иргэд ба үндсэн хуулийн байгууллагад өөрсдийн гаргасан улс төрийн шийдвэр, үйл ажиллагааныхаа талаар тайлбар гаргах ёстой.

² Улс төрийн боловсролын академийн лекцийн эмхэтгэл. УБ., 2001., х.20

³

Хариуцан тайлагналын үр дүн нь улираан сонгох өөрчлөн солихоор илэрнэ. Хариуцлагатай тайлагналтай удирдагчид гэдэг нь иргэдийн хүсэл сонирхлыг /мөн хуулийг/ гүйцэлдүүлэхүйц шийдвэр гаргагчид байдаг. Засаг төрийн зүгээс өөрсдийн үйл ажиллагааны талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэхээс гадна гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг


тайлбарлах нь хариуцан тайлагналын гол зарчим байна. Ардчилсан шударга сонгуулиар сонгогдсон төлөөлөгчид нь иргэд ба эрх баригчдын хоорондын хариуцан тайлагнах харилцаанд гол гүүр болох ёстой. Өрөөр хэлбэл сонгогдсон төлөөлөгчид иргэдийн ашиг сонирхолын асуудлаар төр засгийн байгууллагад шууд хандаж, дээд түвшинд засгийн газрыг огцруулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Хариуцан тайлагнах хэвтээ тогтолцоо: Төрийн байгууллага, эрх баригчдын зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, энэ талаараа гаргасан мэдээ, мэдээллүүдийг өөрийн бүрэн эрхийн дагуу хянан шалгаж, мониторинг хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий төрийн институт ардчилсан нийгэмд заавал байх ёстой.

Тухайлбал парламент дахь сөрөг хүчин, парламентын хянан шалгах хороод, үндсэн хуулийн шүүх, аудитийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, хараат бус сонгуулийн байгууллага, омбудсмэн зэрэг институтууд байдаг.

Улс орон бүрт янз бүрийн нэртэй боловч чиг үүрэг нь ижил омбудсмэний байгууллагууд байдаг. Эдгээр нь төрийн байгууллага, сонгогдсон төлөөлөгчид үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаад хяналт тавьж, энэ тухай иргэдийн шаардлага, мэдээллийг хүлээн авч, шаардлагатай бол авлигийн эсрэг хороо, шүүх зэрэг байгууллагуудад хэргийг шилжүүлдэг байна.

Ардчиллын зарчим, үнэт зүйлс:



Ардчилсан зарчим гэдэг нь “Цөөнхийн ашиг сонирхлыг хүндэтгэн, тэднийг байр сууриа илэрхийлэх эрхээр хангасан нөхцөлд олонхийн саналаар шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах зарчим”-ыг ойлгоно.

Ардчилал нь нийгмийн олон ургальч үзэл, өөр хоорондоо зөрчилдөж болох үзэл бодол, түүнийгээ илэрхийлэн хамгаалах эрх чөлөөнд тулгуурладаг бөгөөд нийгмийн харилцаанд зайлшгүй баримтлах зарчмуудтай байна. Эдгээр зарчмууд нь хууль болон улс төрийн соёлын хэм хэмжээгээр нөхцөлдөж, ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс болдог.

Зураг 3. Ардчиллын зарчим, үнэт зүйлс

Эх сурвалж: ChatGPT-ийн туслалцаатайгаар бүтээв.

Ардчиллын зарчмууд нь олон нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, даган мөрдөгдөж байгаа утгаараа үнэт зүйлс болдог байна.⁴

⁴ Д.Ганбат. Ардчиллын үнэт зүйлс, зарчим. УТБА-ийн лекцийн эмхэтгэл УБ., 1999.,х.29

Ардчиллын үнэт зүйлс:

• Эрх чөлөө

- Ардчилсан нийгэмд хувь хүн өөрийн үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй. Эрх чөлөө нь хувь хүний өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд чөлөөтэй оролцох нөхцлийг хангадаг. **Эх сурвалж:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Тунхаглал, 1948 он, 19-р зүйл.

• Тэгш байдал

- Нийгэмд хүн бүр тэгш эрхтэй байх ёстой. Арьс өнгө, хүйс, нас, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн гарал гэх мэтээр ялгаварлан гадуурхалгүйгээр хандах зарчим юм. Энэ нь хүний эрхийг хамгаалах, шударга нийгмийг бий болгоход чухал үүрэгтэй. **Эх сурвалж:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Тунхаглал, 1948 он, 1-р зүйл.

• Шударга ёс

- Ардчилалд хууль, шударга ёс нь нийгмийн үндсэн суурь болж, хүн бүрийн эрхийг хамгаалахад чиглэгддэг. Шударга ёсыг баримтлах нь нийгэмд итгэлцлийг бий болгож, төрийн ил тод, хариуцлагатай байдалд нөлөөлнө. **Эх сурвалж:** Жон Роулс, *A Theory of Justice*, 1971.

• Хүний эрх

- Ардчилсан нийгэмд хүн бүрийн эрхийг хүндэтгэж, хамгаалах нь үндсэн зорилго юм. Хүний эрх нь хувь хүний нэр төр, эрх чөлөө, хувийн халдашгүй байдал, эрх зүйт нийгмийн үндэс суурь болно. **Эх сурвалж:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Тунхаглал, 1948 он.

• Олон ургалч үзэл

- Ардчилалд олон үзэл бодол, итгэл үнэмшил, соёл, үзэл суртлын ялгаа байхыг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг. Энэ нь иргэдэд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгож, олон талт үзэл санааг хамтатгах боломжтой. **Эх сурвалж:** Жон Стюарт Милл, *On Liberty*, 1859 он.

• Оролцоо ба хариуцлага

- Иргэдийн оролцоо, хариуцлага нь ардчиллын үндэс юм. Ардчилсан нийгэмд иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, оролцох боломжтой байх ёстой бөгөөд төрийн эрх баригчид иргэдийн өмнө хариуцлагатай байх ёстой. **Эх сурвалж:** Ардчиллын үндсэн зарчмуудын тухай тайлбар, Freedom House, 2021.

Эдгээр үнэт зүйлс нь ардчилсан нийгмийг бүтээх, тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн дунд итгэлцлийг нэмэгдүүлэх үндэс болж өгдөг. Ардчилсан нийгмийн амжилт нь эдгээр үнэт зүйлсийг хэрхэн баримталж, хэрэгжүүлж байгаагаас хамаардаг.

Ардчиллын зарчим, үнэт зүйлсийн зарим нэг ойлголтыг доор тайлбарлав.

Эрх чөлөө ба үүрэг хариуцлага:


Эрх чөлөө: Хувь хүн өөрийн хүсэл, итгэл үнэмшил, үйл хөдлөлөө чөлөөтэй илэрхийлэх, бусдын оролцоо, хязгаарлалтгүйгээр шийдвэр гаргах боломж юм. Эрх чөлөө нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд ардчилал болон хүний эрхийн үндэс суурийг бүрдүүлдэг.

НҮБ-ын Хүний Эрхийн Тунхаглалд зааснаар (Нэгдсэн Үндэстний Байгууллага, 1948 он) Эрх чөлөө гэдэг нь “Хувь хүн өөрийн итгэл үнэмшил, үйл ажиллагааг өөрийн хүсэл, бодлоор хэрэгжүүлэх боломж бөгөөд энэ нь бусдын ижил эрх чөлөөг хүндэтгэх, хуулийн хүрээнд байх шаардлагыг агуулдаг”

Эрх чөлөө нь дараах үндсэн ойлголтуудыг агуулдаг:

1. **Хувийн эрх чөлөө** - Хувь хүн өөрийн бодол санаагаа илэрхийлэх, амьдралынхаа талаар чөлөөтэй шийдвэр гаргах эрх.
2. **Нийгмийн эрх чөлөө** - Хувь хүн өөрийн итгэл үнэмшлээ нийгэмд илэрхийлэх, бусадтай харилцах, эвлэлдэн нэгдэх боломж.
3. **Улс төрийн эрх чөлөө** - Хувь хүн засаглалд оролцох, сонгуульд оролцох, төрийн үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулах боломж.

Өөрөөр хэлбэл эрх чөлөөг улс төрийн, иргэний социал гэсэн эрхийн 3 төрлөөс бүрддэг гэж үзэж болно. ⁵



Зураг 4. Эрх чөлөөний тухай ойлголт

Тэгш байдал:

Бүх иргэд улс төрийн тэгш байдалтай байх нь ардчиллын түгээмэл утгыг илэрхийлдэг бөгөөд “хүн бүр хуулийн өмнө ижил тэгш эрхтэй”, “нэг сонгогч-нэг санал” гэсэн ойлголтууд ардчиллын тулгуур зарчим юм.

Ардчилсан нийгэм нь иргэн бүрийг арьсны өнгө, нас хүйс, үндэс угсаа, шашин, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахыг хориглож, тэдний тэгш эрхийг баталгаажуулж, хуулиар хамгаална.

⁵ Зүүн Азийн Барометр Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа УБ., 2005., х.33

<p style="text-align: center;">Улс төрийн тэгш байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хүн бүр сонгуульд саналаа өгөх ижил боломжтой • Хүн бүр өөрийн үзэл бодлоор саналаа өгөх эрх чөлөөтэй • Хүн бүрийн санал ижил жинтэй. 	<p style="text-align: center;">Хуулийн өмнө тэгш байх</p> <p><i>Хүн бүр хуулиар адилхан хамгаалагдаж, шүүх хуулийн байгууллагад хандах, асуудлаа шийдвэрлүүлэх, туслалцаа авах ижил эрхтэй.</i></p>
<p style="text-align: center;">Социал тэгш байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хүний өөрийн чадавхитай холбоогүй арьсны өнгө, шашин шүтлэг, хөрөнгө чинээ зэргээс үүдэж болох хиймэл саад байж болохгүйг илэрхийлдэг. Анги эсвэл статусын зааг ялгааг үгүйсгэдэг. 	<p style="text-align: center;">Эдийн засгийн тэгш байдал</p> <ul style="list-style-type: none"> • Ардчилсан нийгэмд иргэн бүр эдийн засгийн аюулгүй байдлаа хамгаалуулах, өөрийн хэрэгцээгээ хангахад чиглэсэн чадавхиа ашиглах тэгш боломжтой.

Тэгш боломж
Хүн бүр өөрийн чадавхиа ашиглан нийгмийн статусаа өөрчлөх, хөгжиж дэвших боломжтой.

Эрх зүйт төр

Эрх зүйт төрийн гол шинж нь:

- Бүх иргэд хуулийн өмнө тэгш эрхтэй байна.
- Төрийн захиргааны байгууллагууд бүх шатандаа хуулийн хэрэгжилтийг зохион байгуулна.
- Нийгмийн бүх салбарт авлига хээл хахуулийг багасгах, авлигыг илрүүлэх, шийтгэл хүлээлгэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тууштай хэрэгжүүлнэ.
- Нийгмийн хэв журам сахиулах гүйцэтгэх байгууллага нь мөрдөн байцаалтын үед эдлэх эрхийг оролцуулан хувь хүний хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаална.
- Иргэд эрхээ хамгаалах, шүүхийн аливаа шийдвэрийг давж заалдах эрхээ эдлэх үүднээс шүүхэд хандах ижил, хаалттай бус боломжоор хангагдсан байна.
- Эрүүгийн, иргэний ба захиргааны хэргүүд бүгд шүүхээр шударга шийдэгдэх бөгөөд шүүх бүх шатандаа аливаа улс төрийн нөлөөллөөс хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулна.
- Үндсэн хууль дээд эрхтэй ба түүнийг үндсэн хуулийн шүүх /манайд цэц/ тайлбарлаж сахин хамгаална.

Эрх зүйт төрийн чадамж сул, авилгад өртөмтгий байдал нь дараахь сөрөг үзэгдлүүдийг бий болгодог.

- иргэдийн оролцоо, тэр дундаа ядуу ба нэн ядуу хүмүүсийн оролцоо хязгаарлагдмал болох
- хүний эрх эрх чөлөөнд итгэх итгэл сулрах
- нийгмийн чинээлэг хэсэг, нөөцөд ойрхон хэсэг нь шүүх, бусад эрх мэдэлд хандах илүү боломжтой болох, ингэснээр шийдвэрт нөлөөлөх
- авлига хээл хахууль газар авч, эрх мэдлээ урвуулан ашиглах явдал нэмэгдэх
- улс төрийн өрсөлдөөн гажих, шударга бус болох зэрэг үзэгдэл илрэх
- иргэд төрийн үйл ажиллагаа, сонгосон төлөөлөгчдөө хянах, боломжгүй болох
- Төрийн хариуцлагатай байдал, тайлагнах, ил тод байх зарчим алдагдах.

Мэдлэг бататгах дасгал ажил.

Дасгал ажлын зорилго:

- Ардчиллын үнэт зүйлс (эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, олон ургалч үзэл гэх мэт)-ийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх
- Нийгэмд илэрч буй эдгээр үнэт зүйлсийн ач холбогдлыг тунгаан ярилцах.
- Хамтын хүчээр ардчиллын үнэт зүйлсийг хэрхэн тэтгэх арга замыг тодорхойлох.

Дасгал ажлын заавар: Ардчиллын үнэт зүйлсийн мод

1. Дасгалын алхмууд:

Алхам 1. Модны үндэс болон мөчир зурах (Харилцан ярилцах):

- Том цаасан дээр (эсвэл самбар дээр) мод зурж, модны үндэс хэсэгт ардчиллын үндсэн зарчмуудыг бичихийг оролцогчдоос хүснэ.
- Оролцогчид "үндэс" хэсэгт өөрсдийн үзэл бодлоор ардчиллын үнэт зүйлийн ач холбогдлыг нэмэх ба "мөчир" хэсэгт эдгээр үнэт зүйлсийн өдөр тутмын амьдралд үзүүлэх нөлөөллийг бичиж илэрхийлнэ.

Алхам 2. Хамтын нээлт:

Багууд өөрт оногдсон үнэт зүйлийн талаар ярилцаж, ойлголтоо нэгтгэж тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн илэрдэг талаар дээрх асуултын дагуу жишээгээр тайлбарлана.

- "Ардчиллын энэхүү үнэт зүйл таны амьдралд хэрхэн илэрдэг вэ?"
- Эдгээр үнэт зүйлс нийгэмд ямар нөлөө үзүүлдэг талаар харилцан ярилцах.

Сургалтын үнэлгээ:

- Оролцогчдоос 4 ажиглагч томилж, багуудын ажилд үнэлгээ өгүүлнэ.

Хичээл 2. Иргэний оролцоо, оролцооны хэлбэрүүд

Зорилго	<ul style="list-style-type: none">Оролцоо, түүний шатлал, түвшин, ач холбогдлын тухай мэдлэг олгох.
Хугацаа	<ul style="list-style-type: none">90 мин
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">Сэдэлжүүлэх дасгал ажил – 15 минМэдлэг олгох – лекц – 60 минМэдлэг бататгах – 15 мин
Аргачлал	<ul style="list-style-type: none">Багшийн лекцДасгал, хэлэлцүүлэгТест, хяналтын асуултууд
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">Хичээлийн слайдСургалтын техник хэрэгсэлМаркер, флипчарт, цаас, скоч
Үнэлгээ	<ul style="list-style-type: none">Асуулт хариулт

1. Сэдэлжүүлэх дасгал ажил

Багш оролцогчдоос дараах хэлц үгнүүдийн утгыг асууж ярилцана.

- ✓ Төрийн төлөө оготно боож үхэх;
- ✓ Эсгий хийх газар нохой хэрэггүй;
- ✓ Сохрын газар сохор, доголонгийн газар доголон г.м.

Сургагч багшид өгөх зөвлөгөө:

“Иргэдийн оролцоо, оролцооны түвшин” хичээлийн хүрээнд бэлтгэсэн танилцуулгыг ашиглан оролцогчдод мэдээлэл өгнө. Үндсэн агуулгын хүрээнд багш ярьж дууссаны дараа тодруулах асуулт байгаа эсэхийг лавлаж, харилцан ярилцана. Сэдвийг дэлгэрэнгүй тайлбарлахдаа өмнөх сэдэлжүүлэх асуулт хариулт, оролцогчдын гаргасан санал, дүгнэлтийг жишээ болгон авч үзнэ.

Сэдэвтэй холбоотой мэдээлэл:

Иргэдийн оролцоо



Оролцоо нь иргэдийн эвлэлдэн нэгдэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бүтээлчээр оролцох чадавх боломж дээр тулгуурлана. Өөрөөр хэлбэл аливаа асуудлаар ашиг сонирхол нь ямар нэгэн байдлаар хөндөгдөх хүмүүс тухайн асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж

Сайн ардчилал нь уг албан ёсны эрхээ шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөхүйцээр эдлэх боломжийг бүх иргэдэд бодитойгоор ханган баталгаажуулсан байх ба үүнд санал өгөх, эвсэлдэн нэгдэх, зохион байгуулагдах, эсэргүүцэл илэрхийлэх болон өөрсдийн эрх ашгийн үүднээс лоббийн үйл ажиллагаа явуулах зэргийг ойлгоно.

Оролцооны талаарх ойлголтыг ардчиллын зарим сонгодог төлөөлөгчдийн тодорхойлсноор авч үзвэл:⁶

- Нийгэмд шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан нийгэм-улс төрийн үйл ажиллагааг хариуцлага, хувь хүний бие даасан байдалд тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй. Учир нь хувь хүний хүсэл мөрөөдлийг бусад хүмүүс бүрэн төлөөлөх боломжгүй юм. (Roussesu, Франц, 1712-1778)
- Бүх ард түмэн өөрсдийн бүрэн эрхт байдлын талаар дуу хоолойгоо илэрхийлдэг нь ард түмэнд олгогддог бүрэн эрхт байдал, төрийн хянах хэлбэр юм. Бүхий л засаглалын менежмент хэрэгжиж байсан үедээ зөв тогтолцоо гэж хүлээн зөвшөөрөгддөг ч сул тал нь илэрдэг. Харин иргэдийн оролцоо бол нийгмийн бүхий л цаг үед хүлээн зөвшөөрөгдсөн систем юм. (Mill, Англи, 1806-1873)
- Оролцоо, түүний бие даасан байдал нь сонирхолтой, маш чухал ажил бөгөөд санаачилга бүхий оролцооны ардчиллыг бэхжүүлэх нь эрх мэдлийг чухалчлах аюулаас зайлсхийхэд нэн шаардлагатай зүйл юм. (Fromm, Герман, 1900-1980)
- Иргэд улс төр, төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь улс төрд мунхаглалыг дэвэргэдэг. Тиймээс улс төрийн түвшинд иргэд оролцохгүй байх нь улс төрчдөд боломж олгох, тэдэнд улс төрийн хуурамч тоглолт хийх боломжийг өндөрсгөдөг учраас ардчилалд туйлын аюултай. (Walker, Америк, 1933-2010)

Манай Улсын эрдэмтэн судлаачдаас дараах тодорхойлолтыг өгсөн байна:

- Аливаа асуудлын сонирхогч талуудын санаа бодлыг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах үйл явц юм. ⁷
- Оролцоо гэдэг нь хүлээж суух бус, аливаа асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолой, өөрийн санал бодлоо нэмэрлэх, хийж бүтээх, идэвхтэй хяналт тавих үйл ажиллагаа юм. ⁸
- Иргэдийн оролцоо ардчиллын үндсэн үзүүлэлт болдог бөгөөд иргэд засгийн эрх мэдэл, төрийн удирдах эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа эсэхийг илэрхийлдэг юм. ⁹
- Иргэдээс төрийн байгууллага, төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих, тэдгээрт нөлөөлөхийн тулд хийж байгаа аливаа үйлдлийг иргэдийн оролцоо гэж ойлгож болно. ¹⁰

Эдгээр тодорхойлолтоос дүгнэхэд оролцоо гэдэг нь нийгэмд тулгамдсан аливаа асуудлаар иргэд төр засгийн байгууллагуудад санаа бодол, дуу хоолойгоо хүргэж, төрийн үйл ажиллагаанд оролцох эрх мэдлээ хэрэгжүүлэх үйл явц юм.

⁶ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. МУИС, КАС. УБ., 2019. 197 дахь тал

⁷ Захиргааны шинжлэх ухааны тайлбар толь. УБ., 2022. 225 дахь тал

⁸ Иргэний танхим, иргэний оролцоо. УБ., 2015. 7 дахь тал



⁹ Иргэний оролцоо. Гарын авлага. ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг. УБ., 2019. 7 дахь тал

¹⁰ Н.Мягмарцоож. Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ., 2012. 11 дэх тал

Оролцоо нь аливаа асуудлаар ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөх хүмүүс тухайн асуудлаар шийдвэр гаргах, бодлого тодорхойлох үйл явцад хэр зэрэг оролцож байгаагаар тодорхойлогдоно.

Эдгээр тодорхойлолтоос дүгнэхэд оролцоо гэдэг нь нийгэмд тулгамдсан аливаа асуудлаар иргэд төр засгийн байгууллагуудад санаа бодол, дуу хоолойгоо хүргэж, төрийн үйл ажиллагаанд оролцох эрх мэдлээ хэрэгжүүлэх үйл явц юм.

Хүснэгт 1. Оролцооны ойлголт

	<p>Оролцоо бол эрх</p> <ul style="list-style-type: none"> • Иргэний болон улс төрийн эрх’ • Өөрсдийн дуу хоолойгоо шийдвэр гаргагчдад хүргэх эрх; • Мэдлэг, мэдээлэл олж авах эрх; • Хамгаалуулах эрх; • Эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
	<p>Оролцоо бол үүрэг</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн хууль ёсыг сахиж, ард түмнийхээ түүх соёлын үнэт өвийг дээдлэн хүндэтгэх, эзэмших; • Эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрлөх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах; • Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; • Хуулиар ногдуулсан албан татвар төлөх
	<p>Оролцоо бол хөгжлийн түлхүүр</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ардчиллыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах, хөгжлийн бусад санаачилгуудыг амжилттай хэрэгжүүлэх түлхүүр болно.
	<p>Оролцоо бол арга</p> <ul style="list-style-type: none"> • Оролцоо нь иргэд мэдлэг мэдээлэл олж авах, дадлага туршлага, бүтээлч идэвхтэй хандлагыг олж авах аргын нэг мөн.

Иргэдийн оролцоо гэдэг нь хөгжлийн асуудлаарх бодлого, шийдвэр, түүний хэрэгжилтэд иргэд нөлөөлж, хяналт тавих үйл явцыг хэлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болох ардчилсан ёсны зарчим нь төрийн бодлого, шийдвэрийг иргэд мэдэх боломжтой, аливаа үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, нээлттэй, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд оролцох боломжтой нөхцөлд жинхэнэ утгаараа хэрэгжинэ.


Иргэдийн оролцоо дараах боломжийг олгоно:

- Иргэд өөрсдийн амьдран суугаа нутаг дэвсгэрийн хөгжлийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолойгоо хүргэх;
- Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
- Шаардлагатай мэдлэг, мэдээллийг олж авах;
- Өөрийн болон бусдынхаа эрх ашгийг хамгаалах зорилгоор нэгдэж нягтрах боломж олгоно.



Зураг 4. Оролцоонд суралцах мөрдлөг

Оролцооны шатлал: Иргэдийн оролцооны асуудлаар мэргэшсэн АНУ-ын судлаач Ш.С.Арнштейн оролцооны загварыг 3 түвшин, 8 үе шаттай боловсруулжээ.



Зураг 4. Иргэдийн оролцооны шатлал (Ш.С.Арнштейны ангилснаар)

Үл оролцох:

1. **Элдвээр аргалах:** Ж: иргэдийг шийдвэр гаргах эрх мэдэл хэрэгжүүлж болохооргүй нөхцөлд удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсвэл тэднийг ямар ч эрх мэдэлгүй болгох.
2. **Тушаал, даалгавар:** Орон нутгийн засаг захиргааны зарим удирдлага иргэдийн санал зөвлөмжийг сонсох дургүй, түүний оронд оршин суугчдад хог хаягдлаа зайлуулах гэх мэт тушаал, даалгавар өгдөг. Энэ хандлагыг өөрчлөх.

Хэлбэрдэх:

1. **Мэдээлэл:** Иргэдийн эрх, хариуцлага, боломжийн талаар тэдэнд мэдээлэл өгөх нь оролцоог хууль ёсны болгох хамгийн чухал бөгөөд эхний шат юм. Гэхдээ мэдээллийн урсгал 2 талын тэгш хэмт байх ёстой.
2. **Зөвлөгөөн:** Оролцоо ямар түвшинд байгаа нь юуг хэрхэн хийх, хэн хийх тухай шийдвэрт зөвлөгөөн хэрхэн нөлөөлөхөөс шалтгаалдаг.
3. **Тайвшруулах:** Иргэд ямар нэг хэлбэрээр нөлөө үзүүлж болохоор байвч эрх баригчдын олгосон эрх мэдэл бэлэгдлийн шинжтэй байх тохиолдол байдаг.

Иргэд эрх мэдэлтэй байх:

1. **Түншлэл:** Төлөвлөх, шийдвэр гаргах болон бусад хариуцлагын талаар харилцан тохиролцсоны үндсэн дээр эрх мэдлийг иргэд, эрх баригчдын хооронд хуваарилах. Энэ хэлбэр орон нутгийн иргэд Зааварын тодорхой хэлбэрт орсон, уг байгуулал нь гишүүдийнхээ өмнө хариуцлага хүлээдэг, санхүүгийн эх үүсвэртэй байх нөхцөлд зохих үр дүнд хүрдэг.
2. **Эрх мэдэл шилжүүлэх:** Иргэд тодорхой нэг хөтөлбөрийн хувьд шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх.
3. **Иргэдийн хяналт:** Иргэд аливаа хөтөлбөр, байгууллыг удирдаж, бодлого менежментийнх нь талаар бүрэн хяналт тавьж чаддаг, гадны аливаа нөлөөллийн улмаас нөхцөл байдлыг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд гэрээ хэлцэл хийх эрх мэдэлтэй байх.

Шийдвэр гаргах үйл явц дахь оролцооны түвшнийг дараах байдлаар ангилж байна. Үүнд:



Зураг 5. Иргэдийн оролцооны түвшин

- **Мэдээлэх:** Төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх.
- **Зөвлөх:** бодлого, шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг сонсох.
- **Хамтрах:** Иргэд зарим шийдвэр гаргахад эрх мэдэлтэй байх.
- **Эрх мэдэлжүүлэх:** Иргэд эцсийн шийдвэр гаргахад ихээхэн эрх мэдэлтэй байх.

Иргэдийн оролцоо яагаад хэрэгтэй вэ?

- Оролцогч талуудын хамтын ажиллагааг бий болгоно.
- Гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хандлага, итгэл нэмэгдэнэ.
- Бодлого, шийдвэр зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээтэй зөрчилдөхгүй байх нөхцөл бүрдэнэ.
- Бодлого, шийдвэрийн залгамж чанар, тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц ил тод, нээлттэй болж иргэдийн хүлээх хариуцлага нэмэгдэнэ.

Төр нь иргэнээ сонсдог, иргэн нь төрийн үйл хэрэгт оролцдог түншийн харилцаа тогтох, бие биенээ хүндэлдэг хамтрагчид болоход эерэг нөлөөтэй.

Үүрэг хариуцлага

Төр засгийн зүгээс иргэдийнхээ эрх ашиг, эрэлт хэрэгцээ, хүсэн хүлээж байгаа асуудлаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх хариуцлага нь ардчиллын үр дүнгийн нэг хэмжүүр болдог.

Б.Пауэлийн тайлбарласнаар “иргэдийн хүсэн хүлээж буй бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхийг” ардчиллын үйл явц нь нөхцөлдүүлж байгаа бол ардчилсан төр Засаг нь хариуцлагатай байна гэж үздэг байна.¹¹ Энэхүү ардчиллын үйл явц нь дараахь уялдаа холбоогоор илэрнэ:

¹¹ Зүүн Азийн Барометр Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа УБ., 2005.,х.38

- Иргэдийн сонголт олон хэмжүүрт бодлогын тэргүүлэх чиглэлийг намууд нэгтгэн өрсөлдөөний замаар үндэсний бодлого болгоно.
- Иргэдийн илүүд үзэж дэмжсэн байр суурийг шийдвэр боловсруулагчид засаг төрийн бодлого болгон нэгтгэнэ.
- Сонгуульт албан тушаалтнууд энэхүү бодлогын байр суурийг бодит үр дүн болгож хэрэгжүүлнэ.

Иргэдийн сэтгэл ханамж, ардчиллын талаархи үнэлгээг судалсан судалгааны дүнгээр төр засгийн хариуцлагатай байдал ямар түвшинд байгааг гаргаж болно¹².

Мэдлэг бататгах дасгал ажил

Мэдлэг бататгах зорилгоор дараах үнэлгээний тестийг ашиглана.

Оролцогчид тус бүрдээ тестийг бөглөсний дараагаар хариултыг ярилцаж, мэдлэгээ бататгана.

Тест 1.

1. *Хамгийн оновчтой, зөв хариултыг сонгоно уу.*
Иргэдийн оролцоо гэдэг нь хөгжлийн асуудлаарх иргэд нөлөөлж, хяналт тавих үйл явцыг хэлнэ.
 - a. Бодлого, төрийн үйл ажиллагаанд
 - b. Төрийн үйлчилгээнд
 - c. Бодлого, шийдвэр, түүний хэрэгжилтэд
 - d. Аливаа төсөл, хөтөлбөрт
2. *Ш.С.Арнштейн оролцооны загварын “хэлбэрдэх” гэсэн түвшинд аль нь хамаарах вэ?*
 - a. Хэлбэрдэх
 - b. Мэдээлэх
 - c. Иргэдийн хяналт
 - d. Түншлэл
3. *“Бодлого, шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг сонсох” гэдэг нь иргэдийн оролцооны аль түвшинд хамаарах вэ?*
 - a. Мэдээлэх
 - b. Зөвлөх
 - c. Хамтрах
 - d. Эрх мэдэлжүүлэх
4. *“Иргэд улс төр, төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь улс төрд мунхаглалыг дэвэргэдэг” хэмээн тодорхойлсон судлаачийн нэрийг тэмдэглэнэ үү.*
 - a. Rousseau
 - b. Mill
 - c. Walker
 - d. Fromm
5. *Түншлэх гэдэгт аль нь харгалзах зөв хариулт вэ?*
 - a. Иргэдийн эрх, хариуцлага, боломжийн талаар тэдэнд мэдээлэл өгөх, хамтрах
 - b. Иргэд ямар нэг хэлбэрээр нөлөө үзүүлж болохоор байна гэж үзэх
 - c. Асуудлыг шийдвэрлэхэд эрх мэдлийг иргэд, эрх баригчдын хооронд хуваарилах
 - d. Иргэд тодорхой нэг хөтөлбөрийн хувьд шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх

¹² Мөн тэнд.

Хичээл 3. Сонгууль, сонгуулийн тогтолцооны төрлүүд

Зорилго	Сонгууль, сонгуулийн тогтолцооны тухай болон сонгуулийн тогтолцооны төрөл, ялгаа, давуу болон сул талуудын мэдлэг олгох
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Сонгууль, сонгуулийн ач холбогдол,• Сонгуулийн системийн төрлүүд• Монгол Улсын сонгуулийн системийн онцлог
Хугацаа	<ul style="list-style-type: none">• 120 мин
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 15 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 30 мин• Сургалтын үнэлгээ 15 мин
Аргачлал	<ul style="list-style-type: none">• Багшийн лекц• Дасгал, хэлэлцүүлэг• Сонгуулийн үр дүнгийн шинжилгээ
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник хэрэгсэл• Маркер, флипчарт, цаас, скоч
Үнэлгээ	<ul style="list-style-type: none">• Асуулт хариулт

Сургагч багшид өгөх зөвлөгөө:

Монгол Улсад ямар төрлийн сонгуулийн тогтолцоо хэрэглэгдэж байгаа, цаашид сонгуулийн системдээ ямар нэгэн өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байгаа эсэхийг ярилц. Санал болгож буй өөрчлөлт нь сонгогчдын боловсрол, төлөөлөл нь хангагдахгүй байгаа нийгмийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлж болохыг мөн ярилцана.

Сэдэлжүүлэх дасгал:

-

Сэдэвтэй холбоотой мэдээлэл

Сонгууль, сонгуулийн ач холбогдол:

Сонгууль гэдэг нь иргэд өөрсдийн төлөөлөгчдийг буюу төрийн эрх баригчдыг сонгох, төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг олгодог ардчиллын үндсэн механизм юм. Сонгуулиар дамжуулан иргэд улс төрийн оролцоогоо илэрхийлж, өөрсдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудалд нөлөөлөх боломжийг бий болгодог.

Сонгуулийн ач холбогдол:

1. Иргэдийн оролцоог хангах

- Сонгууль нь иргэдийн төрийн бодлого, засаглалд оролцох, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх арга зам юм. Сонгуулиар дамжуулан иргэд улс төрийн эрх мэдлийг хуваалцаж, нийгэмд өөрийн хувь нэмрийг оруулж буйгаа мэдэрдэг.

2. Төлөөллийн засаглалыг бий болгох

- Сонгууль нь ардчилсан нийгэмд төлөөллийн засаглалыг бий болгох үндэс юм. Ард иргэд өөрсдийн төлөөлөгчдийг сонгосноор тэдний нэрийн өмнөөс засаглах эрхтэй хүмүүсийг тодорхойлж, төрийн засаглалд оролцох боломжтой болно.

3. Засаглалын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх

- Сонгуулиар төрийн удирдлагууд ард түмний өмнө хариуцлага хүлээдэг бөгөөд дараагийн сонгуулиар тэднийг солих боломжтой учир төрийн үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдал бий болдог. Энэ нь авлига, буруу үйлдэл зэргийг хязгаарлах нөлөөтэй.

4. Нийгмийн тогтвортой байдлыг хангах

- Сонгууль нь нийгэмд тогтвортой байдлыг бий болгодог. Ардчилсан сонгууль нь нийгэмд зөрчилдөөн, үймээн самууныг багасгаж, өөрчлөлтийг тайван, хууль ёсны дагуу хэрэгжүүлэх боломж олгодог.

5. Шинэ бодлого, санаачилгыг дэмжих

- Сонгуулийн явцад өрсөлдөөнт орчин бий болж, улс төрийн нам, нэр дэвшигчид шинэ бодлого, санаачилгуудыг танилцуулдаг. Энэ нь нийгэмд шинэчлэл, хөгжлийн боломжийг нэмэгдүүлдэг.

6. Ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэх

- Сонгууль нь ардчиллын үндсэн үнэт зүйлс болох эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсыг хүндэтгэж буйг илэрхийлж, ардчиллын соёл, төрийн тогтолцоог бэхжүүлдэг. Дэлгэрүүлж унших: Ардчилсан нийгэм дэх сонгуулийн ач холбогдол <https://gec.gov.mn/voter/2122>

Сонгууль нь зөвхөн улс төрийн үйл ажиллагаа биш, харин иргэдийн төрийн бодлогод оролцох, өөрсдийн дуу хоолойгоо сонсгох, нийгмийн асуудалд нөлөөлөх чухал арга зам юм. Ардчилсан нийгэмд сонгууль нь иргэдийн эрхийг хамгаалах, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангахад онцгой үүрэг гүйцэтгэдэг.



Сонгуулийн тогтолцоо ба тэдгээрийн онцлог

Сонгууль¹³ болон сонгуулийн тогтолцоо гэж юу болох талаар олон нийт төдийгүй, нэр дэвшигчид маань сайн ойлголтгүй байх нь элбэг.

Сонгуулийн эрх бүхий иргэдийг оролцуулан санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийхийг сонгууль гэдэг¹⁴. Өөрөөр хэлбэл сонгууль гэдэг нь иргэд тэдний өмнөөс шийдвэр гаргах төлөөллөө сонгох үйл явц юм. Сонгууль бол ардчилсан нийгмийн үндсэн шинж бөгөөд ерөнхийлөгч, парламентын гишүүд, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын

төлөөлөгчдийг сонгох арга зам¹⁵.

Зураг 5. Сонгууль

Эх сурвалж: ChatGPT-ийн туслалцаатайгаар бүтээв

¹³ Аливаа улсыг ардчилал ба ардчилсан бус гэж тодорхойлох анхдагч шалгуур нь бүх нийтийн, чөлөөт, шударга сонгууль юм. Э.Гэрэлт-Од. <https://ikon.mn/opinion/1xd1>

¹⁴ ~ IDEA Electoral System Design Handbook

¹⁵ Сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ. Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. Сонгуулийн тухай хууль, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг

Сонгууль нь иргэд улс төрийн үйл явцад оролцох, төрөө сонгож байгуулах, механизмыг бүрдүүлдэг. Энэ нь хувь хүмүүст сонгох эрхээ эдлэх, тэдний амьдралд нөлөөлөх бодлого, шийдвэрийг тодорхойлоход саналаа илэрхийлэх боломжийг олгодог.

Мөн сонгууль нь төрийн эрх мэдлийг тайван, эмх цэгцтэй шилжүүлэх арга хэрэгсэл болж, засаглалын хариуцлага, хууль ёсны байдлыг баталгаажуулдаг. Иймээс сонгууль нь Монголын ард түмэн төрийн болон орон нутгийн өөрөө удирдах эрхээ хэрэгжүүлэх үндсэн арга юм.

Сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулиар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” (МУ-ын Үндсэн хууль, 3 дугаар зүйл 1 дэх хэсэг)

Сонгуулийн тогтолцоо гэж юу вэ?

Бүх нийтийн сонгуулиар өгсөн олон нийтийн саналыг нам, нэр дэвшигчдийн шийдвэр гаргах түвшний “суудал” болгон хувиргадаг үйл явц юм.

Сонгуулийн тогтолцооны хэд хэдэн хэлбэрүүд байх бөгөөд хамгийн товчдоо **сонгогчид тодорхой нэр дэвшигчийн төлөө саналаа өгдөг, эсвэл сонгогчид улс төрийн намыг сонгож, намын авсан нийт саналд үндэслэн суудал хуваарилдаг пропорциональ тогтолцоо, эсвэл эдгээрийн аль алиных нь хувилбарыг агуулсан холимог тогтолцоо** гэж ойлгож болно.

а) Олонхийн тогтолцоо.

Хэн хамгийн олон санал авсан нь сонгуульд ялна. Мажоритар болон плуралит гэсэн 2 төсөөтэй хувилбар байдаг. Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан нь ялагч болдог зарчмыг **плуралит тогтолцоо** гэдэг бол мажоритар тогтолцооны хувьд заавал сонгогчдын үнэмлэхүй олонхын буюу 50 хувиас илүү санал авч байж сонгогддог. Харин хэн ч үнэмлэхүй олонхын дэмжлэг аваагүй бол хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн дунд дахин санал хураалт явуулдаг.

Сонгуулийн тогтолцоо
1. Олонхийн тогтолцоо
2. Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо
3. Холимог тогтолцоо
4. Бусад

Давуу тал:	Шүүмжлэлтэй тал:
<ul style="list-style-type: none"> ✓ Санал хураалт болон сонгуулийн үйл явц нь энгийн ✓ Нэр дэвшигчдээс сонголт хийх зарчим нь тодорхой 	<ul style="list-style-type: none"> ➢ Сонгогчдын санал гээгдэнэ. (51 хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдоход 49 хувийн санал өгсөн сонгогчидын санал гээгддэг). ➢ Иргэд саналаа улс төрийн намд бус нэр дэвшигчид өгдөг учраас намын мөрийн хөтөлбөр, үзэл санаанаас

<ul style="list-style-type: none"> ✓ Сонгогчид болон УИХ-ын гишүүдийн хоорондын уялдаа, харилцаа холбоог дэмждэг ✓ Сонгогчид төрд хариуцлага тооцох боломж олгодог. ✓ Үндэсний олонх биш орон нутаг, тойргийн хэмжээнд сонгогчид нэр дэвшигчээ дэмжих боломжтой ✓ Харьцангуй хүчтэй намууд илүү дэмжлэг авдаг. <p>Хоёр шатлалт системийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Сонгогчдод хоёр дахь боломж олгодог ✓ Хэлэлцээр ба зөвшилцөл ✓ Санал хуваахыг багасгадаг 	<p>үл хамааран улс төрчдийн хувь хүний шинж чанар, хувь хүнд өгөх үнэлгээ давамгайлж, популист улс төрчид сонгогдох магадлалтай.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Сонгуулийн нийт зардал өндөр. ➤ Цөөн гишүүд, дэмжигчидтэй намуудад халгаатай. ➤ Эмэгтэйчүүд, олны танил биш шинээр нэр дэвшигчид, үндэсний цөөнхи, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг бүлгүүдийн төлөлөл сонгогдох магадлал бага. ➤ Улсыг олон жижиг тойрогт хуваадаг учраас бүх нийтийг хамарсан, үндэсний хэмжээний төрийн бодлого орхигдох эрсдэлтэй. ➤ Үндэсний хэмжээний парламентийн хувьд газар нутгийн хязгаараас хэт хамааралтай нь үндэсний ашиг сонирхлын төлөө бус орон нутгийн улс төр хийх нөхцөлийг бүрдүүлдэг.
---	---

б) Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо

Сонгуулийн пропорциональ тогтолцоо нь намын жагсаалтын, холимог гишүүний пропорциональ, санал шилжүүлэх¹⁶ зэрэг хэд хэдэн хувилбар байдаг.

Намуудын авсан саналыг парламентын суудалд хувь тэнцүүлэн хуваарилна. Намууд санал болгож буй нэр дэвшигчдийнхээ жагсаалтыг гаргана. Үүнийг дотор нь хаалттай болон нээлттэй жагсаалт гэж хоёр хуваадаг. Тухайн нам нэр дэвшигчдийнхээ жагсаалтыг өөрөө гаргаж, эрэмбэлж, сонгогчид харин зөвхөн намыг дугуйлах замаар жагсаалтыг дэмжих, эс дэмжих шийдвэр гаргадаг бол хаалттай жагсаалт гэдэг. Ингэснээр жагсаалтын дотор зарим нэг дэмжих боломжгүй нэр дэвшигч байсан ч саналаа өгөх хариуцлагыг сонгогчидод тулгадаг талтай. Харин ихэнхи сонгогчид энэ тохиолдолд жагсаалтыг биш намын мөрийн хөтөлбөрийг дэмжих, намд итгэл хүлээлгэх зэргээр сонголт хийхэд хүрдэг. Энэ тохиолдолд иргэд төлөөлөгчөө шууд сонгох эрх хязгаарлагдаж, намын удирдлагад эрх мэдэл төвлөрдөг.

Нээлттэй жагсаалт гэдэг нь сонгогчид намд санал өгөхөөс гадна дэмжиж буй нэр дэвшигчиддээ санал өгөх боломжтой. Ингэснээр хамгийн их санал авсан нэр дэвшигчид нь тухайн намаас парламентын гишүүн болдог. Нээлттэй жагсаалтын хувьд хэдийгээр иргэдэд өөрийн төлөөлөгчдөө шууд сонгох эрхийг олгодог.

Энэ тогтолцоонд улс төрийн намууд иргэдээс авсан саналын тоогоор тодорхой хэмжээний саналын босго давснаар суудал авах эрхтэй болдог.

Давуу тал	Шүүмжлэлтэй тал:
<ul style="list-style-type: none"> ✓ Хувь тэнцүүлэх шударга зарчим ✓ Жижиг намуудад боломж олгож, хөгжиж буй намуудыг "урамшуулдаг" ✓ Олон намын тогтолцоог дэмжиж энэ нь зөвшилцөл, харилцан ойлголт дээр суурилсан улс төрийн соёлыг бүрдүүлдэг. ✓ Намууд төлөвших, парламентат ёс хөгжих боломжийг бий болгодог. 	<ul style="list-style-type: none"> ➤ Намуудаас илүү зохицуулалт, төлөвшлийг шаарддаг. ➤ Намын төв байгууллагад эрх мэдлийг төвлөрүүлдэг. ➤ Намууд болон сонгогчдын хоорондын холбоо харьцангуй сул. ➤ Хэд хэдэн нам парламентад суудалтай болсноор Засгийн газрыг дангаараа

¹⁶ Сонгогчид олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийг давуу эрхээр эрэмблэх боломжийг олгодог эрэмбийн сонголттой санал хураалтын систем юм. Нэр дэвшигчид сонгогдохын тулд тодорхой саналын квотод хүрэх шаардлагатай бөгөөд сонгогдсон нэр дэвшигчдийн илүүдэл буюу хасагдсан саналыг сонгогчдын хүсэл сонирхолд үндэслэн бусад нэр дэвшигчид шилжүүлдэг.

<ul style="list-style-type: none"> ✓ Цөөнх болон эмэгтэйчүүдийн квотыг хэрэгжүүлэхэд дөхөм ✓ Сонгогчдын санал хамгийн бага гээгддэг. 	байгуулах чадамжтай парламентын олонх бүрдэхгүй байх эрсдэлтэй.(Гэвч үүнийг зарим судлаачид сул тал гэж үздэггүй)
--	---

с) Холимог тогтолцоо

Сонгуулийн холимог тогтолцоо нь нэг мандаттай харьцангуй олонхийн тойрог, пропорциональ тогтолцоог хослуулан хэрэглэх хувилбар. Өөрөөр хэлбэл нэг мандаттай тойргоос парламентийн гишүүдийн тал хувь нь сонгогдож, үлдсэн суудлуудад пропорциональ тогтолцоогоор намын жагсаалтаас гишүүд сонгогддог.

Давуу тал:	Шүүмжлэлтэй тал:
<ul style="list-style-type: none"> ✓ Пропорциональ тогтолцоонд тулгуурлан суудлын тодорхой хэсгийг хуваарилна. Намуудын авсан саналын хувь хэмжээгээр суудлыг хуваарилна. ✓ Улс төрийн олон янзын үзэл бодлыг төлөөлөх боломжийг олгож, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлдэг. ✓ Гишүүд, төлөөлөгчдийг сонгогчидтой шууд холбоотой байлгах, орон нутгийн төлөөллийг хадгалах, иргэд төлөөлөгчтэйгээ хариуцлага тооцох боломжийг олгоно. ✓ Засгийн газрыг тогтвортой байгуулах, төлөөллийг хангах хооронд тэнцвэрийг бий болгож чадна. ✓ Улс төрийн илүү тогтвортой орчинг бүрдүүлж чадна. ✓ Ихэвчлэн эвслийн засгийн газар байгуулахад хүргэдэг бөгөөд өөр өөр намууд засаглахын тулд хамтран ажилладаг. Улс төрд зөвшилцөл, хамтын ажиллагааны соёлыг төлөвшүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> ✓ Сонгогчдын хувьд ойлгох, санал өгөхөд төвөгтэй байдал нь төөрөгдөл үүсгэж, сонгогчдын ирцийг бууруулж болзошгүй. ✓ Пропорционалаар хуваарилагдсан суудлууд нь намуудын авсан саналын хувь хэмжээг бодитоор харуулахад хангалтгүй байж болно. Энэ нь ард түмний санал, суудлын хуваарилалт хоёрын хооронд үл нийцэх, улмаар зөрчилдөөн үүсэхэд хүргэж болзошгүй. ✓ Хэт өндөр босго тогтоовол жижиг намууд сонгогчдын тодорхой хувийн санал авч босго давж чадахгүйбайх магадлалтай. ✓ Хэрвээ нэг нам, эвсэл хэт олон суудал авбал тэдэнд ихээхэн эрх мэдэл өгч, хяналт, тэнцвэрт байдлыг алдагдуулж болзошгүй. Эрх мэдлийн ийм төвлөрөл нь сөрөг хүчний намуудын үйл ажиллагааг хязгаарлаж, ардчилсан хариуцлагыг сулруулдаг талтай.

d) Олонхийн тогтолцоо.

Хэн хамгийн олон санал авсан нь сонгуульд ялна. Мажоритар болон плуралит гэсэн 2 төсөөтэй хувилбар байдаг. Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан нь ялагч болдог зарчмыг **плуралит** тогтолцоо гэдэг бол мажоритар тогтолцооны хувьд заавал сонгогчдын үнэмлэхүй олонхын буюу 50 хувиас илүү санал авч байж сонгогддог. Харин хэн ч үнэмлэхүй олонхын дэмжлэг аваагүй бол хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн дунд дахин санал хураалт явуулдаг.

Давуу тал:	Шүүмжлэлтэй тал:
<ul style="list-style-type: none"> ✓ Санал хураалт болон сонгуулийн үйл явц нь энгийн ✓ Нэр дэвшигчдээс сонголт хийх зарчим нь тодорхой 	<ul style="list-style-type: none"> ➤ Сонгогчдын санал гээгдэнэ. (51 хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдоход 49 хувийн санал өгсөн сонгогчидын санал гээгддэг).

<ul style="list-style-type: none"> ✓ Сонгогчид болон УИХ-ын гишүүдийн хоорондын уялдаа, харилцаа холбоог дэмждэг ✓ Сонгогчид төрд хариуцлага тооцох боломж олгодог. ✓ Үндэсний олонх биш орон нутаг, тойргийн хэмжээнд сонгогчид нэр дэвшигчээ дэмжих боломжтой ✓ Харьцангуй хүчтэй намууд илүү дэмжлэг авдаг. <p>Хоёр шатлалт системийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Сонгогчдод хоёр дахь боломж олгодог ✓ Хэлэлцээр ба зөвшилцөл ✓ Санал хуваахыг багасгадаг 	<ul style="list-style-type: none"> ➢ Иргэд саналаа улс төрийн намд бус нэр дэвшигчид өгдөг учраас намын мөрийн хөтөлбөр, үзэл санаанаас үл хамааран улс төрчдийн хувь хүний шинж чанар, хувь хүнд өгөх үнэлгээ давамгайлж, популист улс төрчид сонгогдох магадлалтай. ➢ Сонгуулийн нийт зардал өндөр. ➢ Цөөн гишүүд, дэмжигчидтэй намуудад халгаатай. ➢ Эмэгтэйчүүд, олны танил биш шинээр нэр дэвшигчид, үндэсний цөөнхи, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг бүлгүүдийн төлөлөл сонгогдох магадлал бага. ➢ Улсыг олон жижиг тойрогт хуваадаг учраас бүх нийтийг хамарсан, үндэсний хэмжээний төрийн бодлого орхигдох эрсдэлтэй. ➢ Үндэсний хэмжээний парламентийн хувьд газар нутгийн хязгаараас хэт хамааралтай нь үндэсний ашиг сонирхлын төлөө бус орон нутгийн улс төр хийх нөхцөлийг бүрдүүлдэг.
---	--

Монгол Улсын сонгуулийн системийн онцлог.

Монгол Улс 1992 оноос хойш парламентын сонгуулийг ихэнхидээ Тухайлбал 1992, 1996, 2000, 2004, 2008, 2016, 2020 онуудад мажоритар тогтолцоогоор явуулж ирсэн бөгөөд харин 2012, 2024 онуудад холимог тогтолцоог ашигласан.



Зураг 6. Сонгуулийн оролцоо
Эх сурвалж: ChatGPT-ийн туслалцаатайгаар бүтээв.

Монгол Улсын сонгуулийн тогтолцоо нь олон удаа өөрчлөгдсөн ч, энэ нь улс төрийн тэнцвэрийг хангах, иргэдийн төлөөллийг нэмэгдүүлэх, ардчилсан зарчмыг бэхжүүлэхэд чиглэгдсэн өөрчлөлтүүд байсан гэж судлаачид үздэг. Монгол Улсын өөрийн онцлогт тохирсон, нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд сонгуулийн мажоритар тогтолцооны хувилбар төдийлөн тохирохгүй байгаа тухай судлаачид болон улс төрчид багагүй хэлэлцэн хэд хэдэн сонгуулийн хуулийн төслийг өргөн барьсаар 2024 онд 2 дахь удаагаа холимог тогтолцоогоор парламентийн сонгуулиа явуулсан.

Монгол Улс 2024 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батлав. Энэхүү өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 126 болгон нэмэгдүүлж, 78 гишүүн тойргоос буюу мажоритар тогтолцоогоор, 48 гишүүн пропорциональ тогтолцоогоор намын жагсаалтаас сонгогдсон юм. Энэ удаагийн УИХ-ын сонгуулийн бас нэг онцлог нь нэр дэвшигчдийн хүйсийн квотыг 30 аас доошгүй байхаар баталж, жагсаалтаар нэр дэвшигчдийн хувьд хүйсээр сөөлжлөн байршуулж, олон улсад хэрэглэгддэг цахилгаан товчны аргыг хэрэглэсэн нь парламентад жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд том түлхэц болсон юм.

Холимог сонгуулийн системийн пропорциональ болон олонхийн (мажоритар) тогтолцооны элементүүдийг хослуулсан байдал нь сонгогчдын хүсэл сонирхлыг илэрхийлэх, газар

нутгийн төлөөллийг хангах хоорондын тэнцвэрт байдлыг хангах боломжтой юм. Холимог тогтолцоог манай улс 2012 оны УИХ-ын сонгуульд мөн ашигласан.

Мэдлэг бататгах дасгал

- Өнгөрсөн сонгуулийн үйл явцын талаар багаараа хэлэлцэнэ.
- Сонгуулиар бий болсон өөрчлөлтүүдийг ярилцаж, шинжилгээ хийнэ.
- Монгол Улсад хамгийн сүүлд хэрэглэсэн парламентийн болон орон нутгийн сонгуулийн тогтолцооны давуу ба сул талыг үннэлж, бодит жишээгээр тайлбарлана.

Хичээл 4. Сонгуулийн оролцоо, хариуцлагатай сонгогч

Зорилго	Сонгуулийн оролцооны хэлбэрүүдийн талаар ойлголт мэдлэг олгох
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Сонгуулийн оролцооны хэлбэрүүд• Сонгогчийн эрх, үүрэг ба хариуцлага
Хугацаа	<ul style="list-style-type: none">• 120 мин
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 15 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 30 мин• Сургалтын үнэлгээ 15 мин
Аргачлал	<ul style="list-style-type: none">• Багшийн лекц• Дасгал- Миний сонголт, миний хариуцлага
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник хэрэгсэл• Маркер, флипчарт, цаас, скоч
Үнэлгээ	<ul style="list-style-type: none">• Асуулт хариулт

Сургагч багшид өгөх зөвлөгөө:

Сонгуулийн оролцоо, түүний статистик тоо мэдээллийг сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаас татан авах, сонгогчийн гарын авлагын зарим мэдээллийг нэмэлтээр ашиглах

Сэдэлжүүлэх дасгал:

Дасгал: “Миний хамтрагчийн сонгуулийн оролцоо”

- Оролцогчдыг хос хосоор нь өөрийн орцолож, санал өгсөн, эсвэл нэр дэвшиж оролцсон сонгуулийн талаар саналаа солилцож, харилцан ярилцах, 10 минут ярилцуулна.
- Цаг дуусмагц оролцогчид хамтрагчийнхаа сонгуулийн оролцооны талаар дүгнэлт гаргаж танилцуулах хийнэ.

Сэдэвтэй холбоотой мэдээллийн товч агуулга:

Иргэдийн сонгуулийн оролцоо: Иргэдийн сонгуулийн оролцоо нь зөвхөн нэр дэвших, санал өгөхөөр хязгаарлагдахгүй. Сонгуулийн оролцоо нь олон хэлбэртэй бөгөөд эдгээр нь иргэдийн төрийн үйл хэрэгт оролцох, нийгмийн асуудлуудад санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодог.

Иргэдийн сонгуулийн оролцооны гол хэлбэрүүдийг дараах байдлаар тодорхойлж болно.

1. Санал өгөх

- Иргэдийн сонгуулийн оролцооны үндсэн хэлбэр нь сонгуулийн үеэр санал өгөх явдал юм. Энэ нь иргэдийн эрх, үүрэг бөгөөд тэд өөрийн хүссэн төлөөлөгчийг сонгох, улмаар төрийн эрх мэдэлд нөлөөлөх боломжийг олгодог.

2. **Олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох**
 - Иргэд төрийн бодлого, хууль тогтоомжийг хэлэлцэх олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, санал бодлоо илэрхийлэх замаар шийдвэр гаргалтад оролцож болно.
3. **Нийгмийн санал асуулга, судалгаанд оролцох**
 - Иргэдийн дунд янз бүрийн сэдвээр санал асуулга явуулж, судалгаа хийж, төрийн болон төрийн бус байгууллагууд санал хүсэлтийг нь тусгадаг. Энэ нь иргэдийн санал, шаардлагыг шууд сонсох хэлбэр юм.
4. **Жагсаал, цуглаанд оролцох**
 - Иргэдийн сонгуулийн болон нийгмийн оролцооны бас нэгэн хэлбэр бол тэмцэл, жагсаал, цуглаанд оролцох явдал юм. Энэ нь төрийн бодлого, шийдвэрт өөрсдийн дуу хоолойг хүргэх, эсэргүүцэл илэрхийлэх арга юм.
5. **Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах**
 - Иргэд өөрсдийн санаачилгаараа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөрт оролцож, орон нутгийн болон улсын хэмжээнд бодлогын түвшний шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой.
6. **Олон нийтийн санаачилга өрнүүлэх, өргөдөл гаргах**
 - Иргэд тодорхой асуудлаар олон нийтийн санаачилга өрнүүлэх, гарын үсэг цуглуулах, өргөдөл гаргах замаар төрийн байгууллагуудыг шийдвэр гаргахад шахалт үзүүлэх боломжтой.

Эдгээр оролцооны хэлбэрүүд нь иргэдийн төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, оролцох, нийгэмд эерэг өөрчлөлт авчрахад тусалдаг.

Сонгогчийн эрх, үүрэг, хариуцлага:

Ардчилсан улс орны иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргах, нийгэмдээ хувь нэмэр оруулах үндсэн үүрэгтэй. Сонгогчийн үндсэн эрх, үүрэг, хариуцлагыг дараах байдлаар тодорхойлж болно.

Сонгогчийн эрх:

1. **Санал өгөх эрх**
 - Сонгогчид өөрсдийн төлөөлөгчөө сонгох санал өгөх эрхтэй. Энэ нь ардчилсан нийгмийн үндсэн эрх бөгөөд өөрсдийн дуу хоолойг төрийн шийдвэрт хүргэх боломжийг олгодог.
2. **Сонголт хийх эрх**
 - Сонгогчид өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээрээ сонголт хийх эрхтэй. Тэд ямар нэгэн дарамт, шахалтгүйгээр хүссэн нэр дэвшигчээ сонгох боломжтой.
3. **Мэдээлэл авах эрх**
 - Сонгогчид сонгуулийн өмнө нэр дэвшигчид, тэдний мөрийн хөтөлбөр, намын үзэл баримтлалын талаар мэдээлэл авах эрхтэй. Энэ нь тэдэнд зөв сонголт хийхэд тусалдаг.
4. **Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх эрх**
 - Сонгогчид сонгуулийн талаар өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд энэ нь олон ургалч үзэл, ардчилсан орчныг бэхжүүлдэг.

Сонгогчийн үүрэг:

- 1. Сонгуульд идэвхтэй оролцох үүрэг**
 - Ардчилсан нийгэмд иргэн бүр сонгуульд оролцох үүрэгтэй. Энэ нь зөвхөн эрх биш, мөн үүрэг бөгөөд төрийн эрх барих өөрсдийн төлөөллөө сонгоход өөрийн хувь нэмрийг оруулах боломж юм.
- 2. Мэдээлэлтэй сонголт хийх үүрэг**
 - Сонгогчид сонголт хийхээс өмнө нэр дэвшигчдийн талаар бүрэн мэдээлэлтэй байж, тэдний мөрийн хөтөлбөр, амлалтуудыг судлах хэрэгтэй. Энэ нь тэдний хувьд хариуцлагатай сонгогч байх үүрэгтэй холбоотой.
- 3. Сонгуулийн үйл явцад хууль дээдлэх үүрэг**
 - Сонгогчид сонгуулийн явцад хууль, дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Санал өгөх явцад аливаа хууль бус үйлдэлд оролцохгүй байх, шударга байдлыг хангах үүрэгтэй.

Сонгогчийн хариуцлага:

- 1. Шударга сонгуульд хувь нэмэр оруулах хариуцлага**
 - Сонгогчид сонгуулийн шударга, ил тод байдлыг хангах, аливаа зүй бус үйлдлээс татгалзах, мэдээлэх үүрэг хариуцлага хүлээж байдаг. Энэ нь нийгмийн шударга ёсыг хамгаалах үндэс болдог.
- 2. Төлөөлөгчдөө хянах хариуцлага**
 - Сонгогчид сонгогдсон төлөөлөгчид өөрсдийн үүргийг хэрхэн гүйцэтгэж байгааг хянах эрхтэй. Энэ нь сонгогчдын дуу хоолойг төрийн үйл ажиллагаанд хүргэх нэг арга зам юм.
- 3. Сонгуулийн үр дүнд хариуцлага хүлээх хариуцлага**
 - Сонгогчид сонгуулийн үр дүнд сонгогдсон төлөөлөгчийн үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Өөрөөр хэлбэл, тэдний сонголт ирээдүйн нийгмийн байдалд нөлөөлөх учраас хариуцлагатай байх ёстой.

Сонгогчийн эрх, үүрэг, хариуцлага нь ардчилсан нийгмийн үндсэн суурь юм. Иргэдийн сонгуульд идэвхтэй оролцох, мэдээлэлтэй сонголт хийх, төлөөлөгчдөө хянах нь ардчиллыг хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах үндэс болдог.

Мэдлэг бататгах дасгал 1. "Миний сонголт, миний хариуцлага"

Дасгалын заавар: Оролцогчдод дараах асуултуудыг хувиарлах, эсвэл сугалуулах байдлаар тарааж, багаар нь хэлэлцүүлнэ.

- "Бидний сонгосон төлөөлөгчийн шийдвэрүүд хэрхэн нийгэмд нөлөөлөх вэ?"
- "Бид хариуцлагатай сонгогч болохын тулд юуг анхаарах ёстой вэ?"
- "Бидний сонголт урт хугацаандаа ямар нөлөөтэй вэ?"

Багууд хэлэлцүүлгийн үр дүнгээ танилцуулж, дүгнэн ярилцана. Багш зарим шаардлагатай мэдээллийг нэмж өгөх замаар мэдлэгийг бататгана.